

**Лувсанданзаны “Алтан товч” дахь
Хүдэй сэцэний сургаал үгийн тухай өгүүлэх нь**

Д.Заяабаатар (МУИС)

Хэдэн зуун дамнан өртөөлж, өнөө бидний үед уламжлан ирсэн оюуны соёлын бодот дурсгалуудыг судлахдаа, зөвхөн нэг өнцгөөс нь харах төдийгөөр өнгөрөх бус монгол хэл, түүх, уран зохиолын цогц баримт болох үүднээс нь хянан үзэж, өргөн хүрээнд нягтлан шинжлэх нь зөв билээ. Тэгэхдээ, жинхэнэ эх хэрэглэхүүнийг “нүдээр үзэж, гараар барин” судлах нь туйлаас эрхэм бөгөөд түүнтэй холбоо сүлбээ бүхий бусад баримтыг ч хамруулах ёстой болно.

Ялангуяа XVII зууны үед зохиогдсон “Чакраварди Алтан хааны тууж”, “Хураангуй алтан товч”, Лувсанданзаны “Алтан товч”, Саган цэцэний “Эрдэнийн товч”, “Шар тууж”, Жамбын “Асрагч нэртийн түүх” зэрэг сурвалж дахь уран зохиолын баримт дурсгалыг эх бичиг судлалын үүднээс харьцуулан нягталж, тэдгээрийн сонгомол эхийг тодруулан гаргах нь хэл, уран зохиол судлагч хэн бүхний анхаарвал зохих зүйлийн нэг болов уу.

Бид энэхүү өгүүлэлдээ 17дугаар зууны эхэн хагаст сударч Лувсанданзаны зохион найруулж, монголын түүх бичлэгт Лу “Алтан товч” хэмээн алдаршсан сурвалж бичгээр уламжлан ирсэн овор хэмжээ бага боловч утга агуулга гүн гүнзгий, холбон сэцэлсэн нэгэн сургаал үгийн талаар товч өгүүлэхийг зорив. Эл сургаал шүлэг бусад түүхийн сурвалжид огт тохиолдохгүй, зөвхөн Лу “Алтан товч”-д гарах учраас эх хэрэглэхүүний хувьд ихээхэн үнэ цэнтэй юм.

Дурдан буй сургаал үгийг Лувсанданзаны “Алтан товч”-ийн гэрэл зургийн эхээс галиглан сийрүүлбэл:

[...LAT IIb] küdei sečen [1] ögüleriin, ta amaqai [2] qayan-i [3] arban köbegün sonus adarq-a-tu [4] ayula-yi abalam ta, aryalı uyuljin-i alam ta, aryalı uyulja-yin miqan-i qubilan qubiyaqui-ača ulam, alaldun teskildün qayačam ta budang-tu ayula-yi abalam ta, buyu soyu alam ta, buyu-yin miq-a-yi qubilan qubiyaqui-ača ulam, butaraldun teskildün qayačam ta čilayu-tu čölü-i abalam ta, čikitei jeğeren-i [5] alam ta, čikitei jegeri-yin miq-a-yi

qubilan qubiyāqui-ača ulam čahēilaldun göhsileldün qayačam ta, tere qabul qayan-u [6] dolayan köbegüd-ün [7], ay-a yabudul inu eyimü buyu yurbiqan yajar-i abalam tede, yularayiqan injayan-i alam tede, yularayiqan injayan-iyān miq-a-yi qubilan [LAT 12a] qubiyāju abqui-tayan, qurimilaldun takilduy-a kemegeđ, qutuy-tu buyan-tu boltuyai kemeju tarqaldum tede küde-tü [8] ayula-yi abalam tede, küderi görügesün-i alam tede, küderi görügesün(-iyen) miq-a-yi qubilan qubiyāju abqui-tagan kündüleldün dayilalduy-u kemeju, küsekü metü sayiqan üge-ben ögüleldüged tarqaldum tede dabaly-a-tu youl-i abalam tede, taulai kiriyul-i alam tede, taulai kiriyul-iyān miq-a-yi qubilan qubiyāju abqui-tayan, takildun kündüleldey-e kemeju, tayalalduqui metü sayiqan üge-ben ögüleldüged tarqaldum tede ta amaqui qayan-u urban köbegüd, aburi jung tan-u mayui, aqu albatu qaračus bolqu ta, tede qabul qayan-u dolayan köbegüd, ey-e ebtei-yin küčün-tür, qamuy-un qayan ulus-un ejen bolumui ja, ta namayi mayu ötege [9] ebügen-i kelebe geju büü ayimas [10] (kilingle), ta aq-a-nar degüü-ner amuraldun sayiqan yabuytun ta kemen ögüleksen ajuu!

Холбон шүлэглэсэн байдлаар нь шинэ үсэгт хөрвүүлбэл:

Хүдэй сэцэн өгүүлрүүн:

Та, Амагай хааны арван хөвгүүн сонс

Адаргат уулыг авлам та (та нар)

Аргаль угалзыг алам та (та нар)

Аргаль угалзын махыг хувиан хуваахуйгаас улам

Алалдан тэсгэлдэн хагацам та (та нар).

Будант уулыг авлам та (та нар)

Буга согоо алам та (та нар)

Бугын махыг хувиан хуваахуйгаас улам

Бутралдан тэсгэлдэн хагацам та (та нар).

Чулуут цөлийг авлам та (та нар)

Чихтэй зээрийг алам та (та нар)

Чихтэй зээрийн махыг хувиан хуваахуйгаас улам

Цавчилдан гөвшилдөн хагацам та (та нар)

Тэр Хабул хааны долоон хөвгүүдийн ая явдал нь ийм буюу.

¹ *Erten-ü qad-un ündüdsüleksen törü yosun-u jokiyal-i tobčilan quriyačsan altan tobči kemekü orosibai*, Оршил бичиж, хэвлэлд бэлтгэсэн Ш.Бира, Улаанбаатар, 1990, 11b-12a; Hans-Peter Vietze, Gendeng Lubsang, *Altan tobči*, Eine mongolische Chronik des XVII. Jahrhunderts von Blo bzan bstan 'jin, Text and index, Токуо, 1992, pp. 8-9; Ш.Чоймаа, *Монголын Нууц Товчоон, Лувсанданзаны "Алтан товч"-ийн эхийн харьцуулсан судалгаа*, Улаанбаатар, 2002, 23дугаар тал.

Гурвихан газрыг авлам тэд
Гулирайхан янзагыг алам тэд
Гулирайхан янзаганы махыг хуви­лан хувааж авахдаа
Хуримлалдан тахилдъя хэмээгээд
Хутагт буянт болтугай хэмээж тархалдам тэд.

Хүдэт (хүдэнт) уулыг авлам тэд
Хүдэр гөрөөсийг алам тэд
Хүдэр гөрөөсний махыг хуви­лан хувааж авахдаа
Хуримлалдан тахилдъя хэмээгээд
Хутагт буянт болтугай хэмээж тархалдам тэд.

Давалгаат голыг авлам тэд
Туулай хяргуулыг алам тэд
Туулай хяргуулын махыг хуви­лан хувааж авахдаа
Тахилдан хүндлэлдье хэмээж
Таалалдахуй мэт сайхан үгээ өгүүлэлдээд
Тархалдам тэд

Та (та нар)
Амагай хааны арван хөвгүүд
Авир зан тань муу
Аху албат харцас болох та.
Тэд Хабул хааны долоон хөвгүүд
Эе эвтэйн хүчинд
Хамгийн хаан улсын эзэн болмуй за.

Та (та нар) намайг муу өтөг өвгөнийг хэлэв гэж буу аймс
(хилэгнэ)
Та ах нар дүү нар амралдан сайхан явагтун та хэмээн өгүүлсэн
ажгуу.

Хүдэй сэцэн бээр Амбагай хааны арван хөвгүүнийг Хабул хааны долоон хөвгүүн адил эе эвтэй байхыг сануулан хэлж байгаа нь энэхүү холбон шүлэглэсэн сургаалын гол агуулга болно. Чухам юуны учир, Хүдэй сэцэн Амбагай хааны арван хөвгүүнийг хатуу үгээр донгодох болов?

"Монголын Нууц Товчоон"-д [SHM §52] *qamuq mongqol-i qabul-qahan meden aba. qabul-qahan-nu qoyina qabul-qahan-nu üge-ber dolo'an kö'üd-iyen bö'etele senggüm-bilge-yin kö'ün ambaqai-qahan qamuq mongqol-i meden aba.* [SHM §53] *biyur-na'ur kölen-na'ur qoyar ja'ura ursi'un-müren-ne бүкүн айри'ut - buiru'ut - tatar irgen-e ambaqai-qahan ökin ökcü ö'esün ökin-iyen hudejü otqu bolun tatar jüyin irgen ambaqai-qahan-ni bariju kitad-un altan-qahan-na a[b]cu otqui-tur ambaqai-qahan besütei gü'in balaqaci e[l]cin-i'er ügülejü ilērün qabul-qahan-nu dolo'an kö'üd-ün dumdatu qutula-da ügülerün harban kö'üd-ün dotora qada'an-taisi-da ügüle ke'en ügülejü ilērün qamuq-un qahan ulus-un ejen bol<u>ju öki-ben ö'esün hudeküi-ben nama-'ar kesetkün tatar irgen-e bariqda'a bi tabun quru'ud-iyen*

*kimul tamutala harban quru'ud-iyar ha'uttala haci minu aburan sorif[t]qun ke'eju ilēju'u"*² хэмээн өгүүлдэг.

"Монголын Нууц Товчоон"-ы эш татсан хэсгээс харахад, Хабул хаан долоон хөвгүүнтэй атал хаан ширээг залгамжлуулахаар Сэнгүм билгийн хөвгүүн Амбагайг нэр заан соёрхжээ. Хожим Амбагай хаан Алтан улсад өгүүтгэгдсэнийхээ "өшлийг өшиж, хяслыг хясах" зарлигийг үр хойчистоо өөрийн элчээр дайлган буулгахдаа "...Хабул хааны долоон хөвгүүдийн дундад Хотулд өгүүл, арван хөвгүүдийн дотор Хадаан тайшид өгүүл" хэмээн онцолсон билээ.

Энд таамаг төдийгөөр хэлэх ухвар мөчид санаа бол, Амбагай хаан бээр Хадаан, Хотул хоёрын аль нэгээр хаан ширээгээ залгамжлуулах бодолтой байсан бөгөөд харин чухам хэнийг нь өргөмжлөхөө эцэслэн шийдээгүй байсан үедээ Алтан улсад хорлогдсон бололтой.

Монголын түүх судлалын ном зохиолд Амбагай хааны гэрээс ёсоор Хотулыг хаан ширээнд өргөмжилсөн гэж нийтэм тэмдэглэсэн байна. Гэтэл "Монголын Нууц Товчоон"-д Амбагай бээр Хотулыг шууд нэр заан, хаанд өргөмжилсөн тухай занги мэдээ огт гарахгүй. Үүнтэй холбогдох өгүүлэмжид Хадаан, Хотул хоёрын нэрийг ямагт хамсуулан бичсэн буй. Тухайлбал, "Монголын Нууц Товчоон"-д "*ambaqai-qahan-nu qada'an qutula qoyar-i nereyitcū ilēkse'er qamug mongqo[!]* tayici'ut onan-nu qorqonaq-jubur quraju qutula-yi qahan bolqaba"³ хэмээн тэмдэглэсэн нь тохиолдлын зүйл бус гэж бодно.

Амбагай хааныг Алтан улсад хорлогдсоны хойно, түүний өшийг хэрхэн авах, хаан ширээнд хэнийг өргөмжлөхийг хэлэлцсэн монгол аймгуудын их хуралдай болсон байх ёстой. Тэр цагт, Амбагай хааны арван хөвгүүн хаан ширээний төлөөх тэмцлээс үүдэж, өөр хоорондоо эе эвдэрч, харин Хабул хааны долоон хөвгүүн нэгэн санаа зорилготой байсны үрээр Хотулыг хаан ширээнд өргөмжилжээ гэсэн үнэнийг нутлах баримт хомс ч үгүйсгэж болмооргүй санааг энэ ташрамд дурдсу.

Өмнөх бодомжийг үндэс болгон дүгнэвэл, Амбагай хааны арван хөвгүүний хаан ширээний төлөөх тэмцлээс үүдсэн эвдрэл, тэдний эе найргүй байдал нь Хүдэй сэцэнээс хатуу үгээр донгодохын гол шалтгаан болжээ. Эндээс, Амбагай хааны арван хөвгүүнийг соён сургаж, холбон шүлэглэсэн үг нь ам дамжсан сурвалжаас эх үүдэлтэй бус түүхэн учир холбогдолтой баримт гэдгийг тодруулж болно.

"Судрын чуулган"-д тэмдэглэснээр, "Амбагай хаан үрэгдсэн тухай мэдээ авмагц Хадан (Хадаан Д.3) тайж, Туда ба Ёсүхэй баатар, монголчуудын улсууд, олон аймгийнхан Амбагай хааны өшөөг өших дайнд мордох тухай зөвлөгөөн хийжээ. Тэгээд Хотол ханыг хан зэрэгт

² I.de Rachewiltz, *Index to the secret history of the mongols*, Bloomington, 1972, p. 22.

³ I.de Rachewiltz, *Index to the secret history of the mongols*, Bloomington, 1972, p. 24.

өргөмжлөөд, бүх цэргээ түүнд захируулан Алтан ханы улс руу довтолжээ"⁴.

Мөн "... хэсэг хугацаа өнгөрсний дараа төрөл төрөгсөд, хөвүүд болон тайчууд аймгийн ноёд хуран цугларч, Амбагай ханы оронд хэнийг хан суулгах тухай зөвлөлджээ. Тэд нэлээд удаан зөвлөлдсөн боловч хэнийг ч суулгахаар тохиролцож чадсангүй. ...Тэр жилийнхээ намрын нэгэн өдөр эзэнтнээ сонгохоор хуран цугларчээ. ...Матухан (Мэтүхүн?) сэцэн өгүүлрүүн: Би юу гэж хэлэх вэ? Хөлөө урхинд хийчихгүйн тулд би болжмор шиг дээдэхгүй. Алтан хараацай нисч нарс модон дээр гарчихаад урхинд орж өгөхгүй. Би бол өчүүхэн харц болохоор үг хэлээр ямар эрхтэйсэн билээ...? Эзэнтэн та бүхэн л цэцэн билгийнхээ сайхан үгсийг айлдацгаах болтугай. Тэгвэл хоёр эх хөхдөг тэлуу унага тарган бөгөөд цатгалан байдаг шиг өчүүхэн харц бид эс нэгдвэл дотоодын аливаа хямрал хагарал, салан задгай байдал төрийн чинь хэрэгт нэвтрэх замаа олно" гэв. Ингээд энэ талаар ба шүлэглэн ярих зүйр цэцэн үг хэлэх, сургаал даалгавар зэргийг холин урсгаж байгаад уйлж хурлаасаа гарч одлоо"⁵ гэсэн тэмдэглэл буй.

Түүхэн сурвалжаас эрэн олсон дээрх баримтаар эш үндэс хийж, Амбагай хааны өшийг хэрхэн авах тухай монгол аймгуудын зөвлөгөөн юм уу, эсвэл тайчуудын хуралдай дээр Хүдэй сэцэн бээр өгүүлэн буй сургаал үгийг хэлсэн байх магадлалтай гэсэн таамаг дүгнэлтийг гаргаж болно.

Эрдэмтэн Ч.Хишигтогтох "Судрын чуулган"-д дүрслэгдсэн энэхүү хуралдааны талбар нь яг Хүдэй сэцэний энэхүү шүлгээр шүлэглэсэн талбар мөн шиг бөгөөд Мэтүхүн сэцэн бол Хүдэй сэцэн, Мэтүхүн сэцэний хэлсэн тэдгээр "толгой холбосон олон өтгөс үг, сэцэн үг, билиг сургаалууд" бол яг Хүдэй сэцэний энэ шүлэг бололтой шиг юм"⁶ гэж ойлгон тэмдэглэсэн нь дээр эшлэсэн сурвалжийн баримт мэдээнээс эх үүдэлтэй юм. БНХАУ-ын судлаач Булаг "Арван долдугаар зууны монгол түүхэн уран зохиол"⁷ хэмээх бүтээлдээ Хүдэй сэцэний холбон шүлэглэсэн үгийг Лувсанданзаны "Алтан товч"-ийн "Билиг сургаалын шүлэг" гэсэн хэсэгт оруулсан байдгийг тэмдэглэе.

Энэ мэт монгол түүхэн сурвалжаар уламжлан ирсэн дурсгалыг эх хэрэглэхүүнээс нь тэнхрүүлэн сэргээж, хэл найруулга, утга агуулгын онцлогийг нэхэн шинжилж, эртний уран зохиолд хамаатах бичиг соёлын сан хөмрөгөө нэмэн баяжуулах явдал чухал билээ. Үүний нэг жишээнд "Хүдэй сэцэний сургаал үг"-ийг оруулах үндэстэй бөгөөд уг эхийн хэл найруулгын тэгш эерүү шинж, утга агуулгын гүн нягт байдал нь монголын

⁴ Рашид ад Дин, *Судрын чуулган*, I боть, Орос хэлнээс эх хэлнээ хөрвүүлсэн Ц.Сүрэнхорлоо, Улаанбаатар, 2002, 193дугаар тал.

⁵ Рашид ад Дин, *Судрын чуулган*, I боть, Орос хэлнээс эх хэлнээ хөрвүүлсэн Ц.Сүрэнхорлоо, Улаанбаатар, 2002, 195-196.

⁶ Kesigtoytay, *Ertien-ü mongyol silüg-ün tegübüri*, Köke qota, 1985, 108-109.

⁷ Bulay, *Arban doluchiyar jayun-u mongyol teüken uran jokiyal*, ÖMAKKQ, 1986, 699-702.

эртний уран зохиолын сан хөмрөгт багтах ёстой гэдгийн бодот үнэлэлт болох юм.

ҮГИЙН ТАЙЛБАР

- [1]. **ᠬᠡᠳᠡᠢ ᠰᠡᠴᠡᠨ** *küdei sečen*
Хүдэй сэцэний тухай занги мэдээ түүхэн сурвалжид төдий л гарахгүй байна. Эрдэмтэн Ч.Хишигтогтох "Судрын чуулган"-д тэмдэглэсэн Мэтүхүн сэцэнийг Хүдэй сэцэн бололтой гэсэн таамаг дэвшүүлжээ.
- [2]. **ᠠᠮᠪᠠᠭᠠᠢ** = **ᠠᠮᠪᠠᠭᠠᠢ** *ambaqai -ambaqai*
"Монголын Нууц Товчоон"-д *ambaqai* гэж буй. Бодончирын долдугаар үе болох Сэнгүм билгэ-ийн хүү. Бодончир → Хабичи_баатар → Мэнэн_тудун → Хачи_хүлүг → Хайду → Чирахай_линху → Сэнгүм билгэ → Амбагай.
- [3]. **ᠬᠠᠭᠠᠨ** *qayan-i*
"Хааны" гэж буулгах ёстой. 17дугаар зууны түүхэн сурвалжуудад *с-i* (-ыг, ийг, -г) хэлзүйн хэлбэрийг харьяалахын тийн ялгалын нөхцөлийн байранд хэрэглэсэн тохиолдол олонтаа таардаг. Энэ нь тухайн цагийн хэл ярианы онцлогийг шууд тусган бичсэнээс үүдэлтэй юм.
- [4]. **ᠠᠳᠠᠷᠠ** *adary-a*
Уул хадны жалга сархиаг ихтэй, юмны гадаргын барзгар байдлыг хэлнэ⁸.
- [5]. **ᠴᠢᠬᠢᠲᠡᠢ ᠵᠡᠭᠡᠷᠡᠨ** *ᠴᠢᠬᠢᠲᠡᠢ ᠵᠡᠭᠡᠷᠡᠨ* *ᠴᠢᠬᠢᠲᠡᠢ ᠵᠡᠭᠡᠷᠡᠨ* *ᠴᠢᠬᠢᠲᠡᠢ ᠵᠡᠭᠡᠷᠡᠨ* *ᠴᠢᠬᠢᠲᠡᠢ ᠵᠡᠭᠡᠷᠡᠨ* *ᠴᠢᠬᠢᠲᠡᠢ ᠵᠡᠭᠡᠷᠡᠨ*
Хулан, зээр тэргүүтнийг гэсэн утгаар гарч байна.
- [6]. **ᠬᠠᠸᠠᠨ** *qabul qayan*
Бодончир → Хабичи_баатар → Мэнэн_тудун → Хачи_хүлүг → Хайду → Байшонхор_догшин → Тумбинай_сэцэн → Хабул_хаан. "Хабул хаан Монголын түүхэнд нэн их гавьяа байгуулсан, улс төр цэргийн том зүтгэлтэн байжээ. Хабул хаан XII зууны тэргүүн хагаст нас барахдаа хаан ширээгээ долоон хөвгүүнийхээ аль нэгэнд бус Тайчид овгийн Сэнгүн билигийн хөвгүүн Амбагайд өгөхийг гэрээсэлсэн ажээ."⁹
- [7]. **ᠬᠠᠸᠠᠨ ᠬᠠᠭᠠᠨ ᠨᠤ ᠬᠣᠲᠣᠭᠠᠨ ᠬᠡᠳᠡᠢ** *qabul qayan-u dolo'an köbegüd*
"Монголын Нууц Товчоон"-д "*qabul-qahan-nu kö'tüt dolo'an büle'e angqa yeke mu ökin-barqaq bartan-ba'atur qutu[qtu-mönggür qutula-qahan qulan qada'an todo'en-of]cigin ede dolo'an büle'e*"¹⁰ гэж тэмдэглэжээ.
- [8]. **ᠬᠡᠳᠡᠢ ᠲᠦ** - **ᠬᠡᠳᠡᠨᠲᠦ** *küde-tü=küdengtü*
хүдэт=хүдэнт. Утаа тоост, униар будант уул гэсэн утгыг уг эхэд илтгэнэ.
- [9]. **ᠣᠳᠡᠭᠡ** = **ᠣᠳᠡᠭᠡ** *ötege=ötegi*
1. Хөгшин настан 2. Түрүү, ахлагч, дарга¹¹
- [10]. **ᠠᠶᠢᠮᠠ** *ayimas*
Хилэгнэн зэвүүрхэх ба зэмлэн донгодох¹²

⁸ Sečenčoytu, *Mongyol üges-ün ijaγur-un toli*, ÖMAKKQ, 1987, 123дугаар тал.

⁹ Л.Жамсран, С.Дэмбэрэл, Ж.Урангоо, *Монгол түүхийн бага нэвтэрхий толь*, III (С-Я), Улаанбаатар, 2002, 104дүгээр тал.

¹⁰ I.de Rachewiltz, *Index to the secret history of the mongols*, Bloomington, 1972, p. 21.

¹¹ Sečenčoytu, *Mongyol üges-ün ijaγur-un toli*. ÖMAKKQ, 1987, 458дугаар тал.

¹² Sečenčoytu, *Mongyol üges-ün ijaγur-un toli*, ÖMAKKQ, 1987, 14дүгээр тал.